САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 06 сарын 10 өдөр Дугаар 203 Улаанбаатар хот

"Стандарт инвестмент ҮЦК" ХХК-ийн
тусгай зөвшөөрлийг сэргээх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, 63 дугаар зүйлийн 63.1.5 Хорооны 2015 оны 406 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай зарим үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэх журам"-ын 8.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Стандарт инвестмент ҮЦК" ХХК-ийн тусгай зөвшөөрлийг түдшэлзүүлсэн нөхцөл байдал арилсан тул үнэт цаасны зах зээлд брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээсүгэй.

2. Хөрөнгө оруулагчид, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн, хууль тогтоомжоор хүлээсэн үүргийг чанд биелүүлж ажиллахыг "Стандарт инвестмент ҮЦК" ХХК /Ч.Жаргал/-д анхааруулсугай.

3. Үйл ажиллагаандаа Компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлж ажиллахыг "Стандарт инвестмент ҮЦК" ХХК /Ч.Жаргал/-д даалгасугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Нацагдорж/-нд даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ,
ДЭД ДАРГА Э.БАТБОЛД

001176